

БҮТЭЖ БУЙ БӨӨ МӨРГӨЛ:

Өнөөгийн монгол бөө нэрийн доторх эрэмбэ ба зөрчил

Д.Бум-Очир

Товч агуулга: Бид бөө хэмээх нэрийн дор эрэмбэ зэрэг, ёс суртахуун, хүч чадал, үйлддэг зан үйл, өмсөж хэрэглэдэг эдлэл зэмсэг, тахидаг хүндэлдэг шүтээнээрээ ихээхэн ялгаатай олон янзын хувь бодгалуудыг судлаж байна. Энэ тогтсон бус, ихээхэн ялгаатай байх мөн чанар зөвхөн нэг бөө эрэмбэ ахин өөрчлөгдөж байгаа үйл явц байхаас гадна бас маш олон янзын бөө нэр өөр өөр эрэмбийг төлөөлөн олон шинж чанаруудыг илэрхийлж байгаа хэрэг юм. Өөрөөр хэлбэл, энэ бол нэг хүмүүний хувирал өөрчлөлтийн тухай асуудал байхаас илүүтэй олон хувь бодгалийн өөр өөр байгаа тухай асуудал юм. Хэрвээ өдгөө “бөө” (shaman), “бөө мөргөл” (shamanism) болон “бөөгийн шашин” (shamanic religion) гэдэг зүйл ийнхүү тодорхой барьцгүй, тийм гэх тэмдэггүй олон төрөлт зүйл юм бол бид цаашидаа “бөө” болон “бөө мөргөл” гэж чухам хэнийг юуг нэрлээд тодорхойлоод байгаагаа дахин шүүн тунгаах хэрэгтэй болж байна. Бидний энэхүү илтгэлд дэвшүүлж байгаа онолын задлан шинжилгээний гол дүгнэлт бол өнөөгийн “бөө” болон “бөө мөргөлийг” нэгтгэн тодорхойлж, нэгэн тогтсон ухагдахуунаар ойлгож тайлбарлах (structured description) боломжгүй тийм зүйл гэдэг санаа юм. Харин өдгөө “бөө” болон “бөө мөргөл” гэдэг бол тийм байх ёстой гэсэн нэгэн тодорхой тогтсон ойлголтоор хандаж болдоггүй, амьд орчил хөдөлгөөн дотор бүтэж бүрэлдэж байдаг, олон талт шинж чанартай зан үйл болон мэдлэгийн цогцолбор юм. Харин өнөөгийн монголын нийгэмд түүнийг бүтээгч нь бөө нэр байхаас гадна бас төр засаг, нийгэм хам олон болон өнгөрсөн болон судлаачид юм. Өөрөөр хэлбэл, “бөө” болон “бөө мөргөл” гэдэг тодорхой тогтсон гэгдэх ойлголтыг бид бүтээж байдаг болохоос биш үнэн хэрэг дээрээ “бөө”, “бөө мөргөл”, “бөөгийн шашин” гэдэг бидний төсөөлж байгаагаас өөр зүйл бодит байдал оршиж байна гэсэн санаа юм.

Түлхүүр үг: Шашин, мөргөл, деконстракшин, эрэмбэ, зөрчил

Удиртгал

Коммунизмын дараах үеийн Монголын нийгэмд бий болсон анхаарал татсан соёлын олон үзэгдлүүдийн нэг нь бөө мөргөл юм. Монголын бөө мөргөлийн өнөөгийн байдлыг дахин сэргэлт (revival) гэж үзэж болох юм. Гэхдээ дахин сэргэлт хэмээн өнгөцхөн хүрээнд авч үзэх нь хангалтгүй бөгөөд харин түүнээс илүү соёлын нэгэн элементийн бүтэж бүрэлдэх (construction and re-construction) үйл явц мэтээр хандах нь түүнийг тайлан тайлбарлах, ухаж ойлгоход тустай юм. Энэ мэтчилэн бөө мөргөл өнөөгийн монголын нийгмийн хамгийн өргөн хүрээг хамарсан, том сэдвүүдийн нэг болоод байгаа атал үүнийг судалж хариу өгөх, тайлбарлах ажил бараг хийгдэхгүй байна. Бараг үндэсний хэмжээний гэж болох бүхэл улс орны өнцөг булан бүрийг хамраад байгаа энэ сэдэв нэг талаас манай нийгэм олон нийтийн хувьд нөгөө талаас эрдэм шинжилгээний хувьд судлан үзүүштэй сонирхолтой асуудал юм.

Тус судалгаанд бидний 1995 оноос хойш цуглуулсаар ирсэн бөө мөргөлийн судалгааны баримт сэлт, угсаатны зүйн (ethnography) эх сурвалж орсон бөгөөд харин задлан шинжилгээний хувьд антропологийн этнографийн судалгааны түвшинд өргөн хэрэглэгддэг тайлан тайлбарлах (interpretation) (Geertz 1973 [2000]) аргыг тус илтгэлийн үндсэн чиг баримжаа болголоо. Ингээд судалгааны эх хэрэглэхүүний агуулгын хувьд өдгөө тулгараад байгаа хэд хэдэн нөхцөл байдлыг авч үзэх бөгөөд үүнд нэгд нь “олон бөө” гэх ойлголт буюу түүн дотроо бөөгийн ёс дэг зан заншил, уламжлалын олон төрөл зүйл байдаг явдал, хоёрт, өнөөгийн бөө нэрийн ёс зүйн асуудал буюу “мөнгө хөрөнгө, өргөл барьцанд шунадаг болсон, архи сархад элдэв зүйлд автах болсон” гэх байдал, гуравт, бөө нэрийн доторх шаталсан захиргаа, дотоод зохион байгуулалт, дахин сэргэлийн мөн чанарыг авч үзэх бөгөөд энэ хүрээнд сүүлийн үед эрс олширсон багш, шавийн зөрчил, багш шавийг бөө болгон онгод тэнгэртэй нь залгуулж өгч чадахгүйд хүрдэгийн учир шалтгааныг авч үзэх болно. Харин дүгнэлтэнд дээр дурдсан гурван зүйл сэдвийг тайлбарлан дэвшүүлж байгаа бидний гол задлан шинжилгээний санал болох өнөөгийн монгол бөө мөргөл *овоо босгож* байгаатай адил зарчмаар явагдаж байна гэсэн санаагаа дэлгэрэнгүй тайлбарлах болно. Өөрөөр хэлбэл, бөө болоод нэн ялангуяа онгодуудын дотор тэдний өөрсдийнх нь нэрлэдэгээр *суудлын эрэмбэ* гэж байх бөгөөд энэ нь нэг ёсондоо онолын задлан шинжилгээний нэр томъёогоор бол “шаталсан захиргаа” буюу *hierarchy* (Dumont 1980) байна гэсэн үг. Харин өнөөгийн монголын бөө мөргөлийн нөхцөл байдал бол энэхүү шаталсан захиргааг *барьж байгуулж бүтээж* (construction) байгаа нэгэн ёсны үйл явц (process) юм. Нэгэнтээ онгод тэнгэрүүдийн эрэмбэ *суудал* дээшлэх тусмаа мэдлэг чадвар, хүч чадал, ёс зүйн хэм хэмжээ ондоошиж байхын сацуу бас бие биенийхээ эрэмбийг үл мэдэх, үл хүлээн зөвшөөрөх явдал гардаг нь

бөө нэрийн дунд зөрчил үүсэх үндсэн шалтгаан болж байна гэж тайлбарлаж болох юм. Энд гарах эх сурвалжуудаас үзвэл маш олон янзын бөө болоод түүнийг тойрсон олон янзын ойлголт байх бөгөөд энэхүү тогтворгүй, хувирамхай, олон чанарт нөхцөл байдал чухам бөө гэж хэн бэ, бөө мөргөл гэж юу вэ гэдэг асуултанд бүрэн хариулах боломжгүй болохыг илтгэж байна. Иймээс бөө мөргөл гэдэг өөрөө бүтэж бүрэлдэж байгаа үйл явц байхаас гадна өөр өнцөгөөс харвал түүнийг бүтээж бүрэлдүүлж байгаа үйл явц бас явагдаж байна гэсэн санаа дэвшүүлмээр байна. Өөрөөр хэлбэл, “бөө”, “бөө мөргөл”, “бөөгийн шашин” хэмээх ухагдахууныг бөө нэр, олон нийт, үндэстэн улс байгуулах улс төрийн зорилго, судлаач эрдэмтэд бүтээж (reconstruct) байдаг ажээ. Судлаачдын бүтээл болон бөө нэр, олон нийтийн дунд байдаг бөөгийн тухай ойлголтууд зохиомол, бүтээмэл (constructed) зүйл болохоос биш бодит байдал, жам ёс, туйлын үнэн биш юм. Тодруулвал бөө гэдэг анхнаасаа нэгэн хувь бодгалийг нэрлэдэг үг байсан бөгөөд харин аажимдаа хоорондоо төстэй олон хүнийг нэгтгэн нэрлэдэг албан ёсны нэр томъёо болон төлөвшсөн байна. Үүний үр дүнд хүмүүс “бөө” (shaman), “бөө мөргөл” (shamanism), “бөөгийн шашин” (shamanic religion) гэж тодорхой нэгэн бүхэл зүйл байгаа мэтээр сэтгэсний үндсэн дээр бий болсон нийгэм соёлын бүтээл гэж үзэх нь зүйд нийцтэй. Өөрөөр хэлбэл, судлаачид ч, бөө нэр ч, төр засаг, бусад олон нийт ч ялгаагүй бөө гэж ийм тийм юм байдаг гэдэг олон янзын *догматик* (dogmatic) ойлголтуудыг бий болгодог тул ийм ойлголт төсөөллүүд бодит байдал дээр бүрнээ нийцэж таарахгүй байх нь түгээмэл юм. Бөө гэдэг олон янзын хүмүүсийг нэрлээд байдаг энэ зүйлийг илүү тодорхой барьцтай болгохын тулд тэднийг нэгтгэн “бөө”, “бөө мөргөл”, “бөөгийн шашин” гэх мэтийн ухагдахуунуудыг бүтээсэн бөгөөд нэг талаас энэ нь нэгтгэж байгаа боловч нөгөө талаар зарим зүйлсийг орхигдуулсан байна. Нэгэнтээ ийм учир дутагдалтай тул энэ тогтсон ойлголтыг буцаан задлаж (deconstruct) байж судлах нь илүү үр дүнд хүрэх болно (Humphrey, Thomas 1994: 11-12 нарыг бас үзнэ үү). Энэ байдал нэг талаас “бөө мөргөл”, “бөөгийн шашин”, “бөө” гэж **тодорхой нэгэн зүйл** байдаггүйг илтгэхээс гадна нөгөө талаас судлаачид, бөө нэр, улс төр, олон нийт янз бүрийн агуулгаар бөө, бөө мөргөл, бөөгийн шашин гэсэн ойлголтуудыг бүтээж байна гэдэг санаа дэвшүүлж байна.

1. “Олон бөө” ба олон төрлийн бөө

Миний бие анх ахмад судлаачдыг даган бөө нэрийн дунд хээрийн шинжилгээний ажил хийх болсон нь 1990 оны дунд үе билээ. Тухайн үед Буриад, Дархад, Духа (Цаатан) бөө нэр гарын хуруунд багтам тоологдож цөөн хэдэн ахмад судлаачид маань ч тэднийг андахгүй мэддэг бараг бүгдтэй нь уулзчихсан байдаг байлаа. Тухайн цагт бөөгийн уламжлал хадгалагдан үлдсэн

байсан угсаатнуудаар бөөгийн уламжлалыг ойлгож Дархад, Буриадууд, Хөвсгөлийнхөнд л бөө байдаг мэтээр ойлгож байсан. Тийм ч учраас одоо хэр “Хөвсгөлийн” гэвэл “бөөгийн удамтай юм байна” гэж сэжиглэх байдал манай нийгэмд түгээмэл болоод байна. Энэ бол мөн л өмнө дурдсан өнөөх бөөгийн талаарх тогтсон сэтгэлгээний нэгэн жишээ юм. Харин тэр үед судлаач бидэнд төрж байсан нэгэн асуулт бол “Халх бөөгийн уламжлал хэзээ нэгэн цагт сэргэх болов уу” гэсэн битүү бодол байсан юм. Харин өнөөгийн өндөрлөгөөс харвал халх бөө сэргэхээр зогсохгүй одоо монгол угсаатнуудын дотор бөөгийн уламжлал нь сэргээгүй угсаатан цөөхөн үлдсэн байна. Нарийвчлан дурдвал, өдгөө бидэнд мэдэгдэж байгаагаар бол Буриад, Дархад, Духа (Цаатан), Хотгойд, Өөлд, Баяд, Дөрвөд, Дарьганга, Сартуул, Урианхай, Торгууд, Тува, Халх, Захчин гэхчилэнгийн дийлэнх монгол угсаатнууд бөөтэй болжээ.¹ Өөрөөр хэлбэл, бөө мөргөлийн сэргэн хөгжиж байгаа явдал шүтлэг мөргөлийн агуулгатайгаас гадна угсаатны ухамсар (ethnicity) сэргэн дэлгэрэх давхар шинж чанарыг агуулж байна.² Угсаа гарлын хувьд ийнхүү дэлгэрч байгаагийн хажуугаар тооны хувьд олон бөгөөд олон янз болсон нь хэн бүхэнд илхэн болоод байна. Хэдий тийм боловч өнөөгийн нөхцөлд бөө нэрийн тоог гаргана гэдэг олон талаасаа бараг боломжгүй зүйл юм. Тухайлбал, чухам бөөг хэрхэн тодорхойлж, мөн биш эсэхийг хэн яаж шалган тогтоох тухай асуудал тодорхойгүй хэвээр байгаа нь бөө нэрийн тоог гаргах боломжгүйд хүргэж байхаас гадна “бөө гэж хэн бэ”, “бөө мөргөл гэж юу вэ” гэдэг асуултанд хариулах ч боломжгүйд хүргэж байгаа юм. Хэдийгээр тодорхой тоо байхгүй ч олшроод байгаа нь бусад олон иш сурвалжаас тодорхой байна. Тухайлбал, судлаач И.Шимакура Дорнод аймгийн дөрвөн буриад сумын хэмжээгээр 2000 онд нийт 120 бөө тоологдсон тухай мэдээлжээ (Shimamura 2004: 199). Түүнчлэн Монголдоо томоохонд тооцогдох бөөгийн холбоо төвүүдийн бөө гишүүдийн тоог сөхвөл Монголын бөөгийн “Голомт Төв” 10 000³, “Тэнгэрийн Сүлдэр” холбоо 600⁴ орчим бөө гишүүнтэй гэдэг албан ёсны баримтаас ерөнхий төлвийг нь ажиглаж болно. Түүнчлэн төв, холбоодуудаас гадна хувь бөө нэр, тухайлбал, 4 жилийн өмнө бөө болсон удган Ө өдгөө 50 гаран

¹ Д. Бум-Очир, 2010, *Бөө мөргөлийн сэргэлтийг үзүүлсэн газрын зураг* (хэвлэгдээгүй).

² Тухайлбал, халх бөө нэр болон онгод тэнгэрүүд монголын бөө мөргөлийг тэргүүлэх учир гэхчилэнгийн угсаа бүлэг ялгасан ойлголт байдаг үүний нэг жишээ юм. А хэмээх Сартуул зааринтай уулзаж байхад “Дархадчууд Барууны 55, Зүүний 44 гэсэн Мөнх Тэнгэрийн зарлигийн гадуурх өөрсдийн тэнгэрийг бий болгож үүнээсээ болж Мөнх Тэнгэрт ихээхэн зэмлэгдэн шийтгэгдэж, эрэмбэ доошилсон. Тиймээс Дархадын бөөг Халхчууд тэргүүлэн жолоодох учиртай болсон” (2010 оны 12 сард уулзан тэмдэглэж авав) тухай хуучилж байсан.

³ 2010 оны 8 сарын 6-нд “Голомт Төвийн” тэргүүн Ш.Сүхбатаас авсан мэдээлэл.

⁴ 2010 оны 8 сарын 4-нд “Тэнгэрийн сүлдэр” холбооны тэргүүн Н.Энхбаатар заарингаас авсан мэдээлэл.

шавьтай⁵ болж шавь нар нь ч бас олон шавьтай болсон байгаагаас үзвэл бөө нэрийн тоо цөөн биш гэдэг нь тодорхой. Үүнийгээ ч дагаад олны дунд “яагаад ийнхүү олон болох болов, эд үнэн үү худал уу”, “бөө мөн биш” гэхчилэнгийн олон асуулт гараад байгаа бөгөөд биднийг судлаач болох үүднээс ийнхүү асууж лавлаж хандсан хүмүүс ч олон байна.

Эрдэм шинжилгээний үүднээс хандаж байгаа судлаачдын хувьд үнэн худлыг тогтоон, олон цөөн байгааг нэг бол буруутгаж эсвэл зөвтгөх гэхээсээ илүү үүний учир шалтгааныг бөөгийн ёс дэг уламжлалаас лавлан тодруулахыг зорьлоо. Бөө болох ёс дэг удам дамждаг гэж олон судалгаанд тодорхой дурдсан байдаг. Тэгвэл өнөөгийн бөө нэр бүгдээрээ удамтай юу гэдэг асуудал тавигдах шаардлагатай гэсэн үг. Бидний мэдэж байгаагаар асууж тодруулсан заарин удгадууд олонх нь удамтай байсан. Харин бөөгийн удамтай гэдгээ мэдээгүй явсаныг онгод тэнгэр нь орж эртдээ удамтай байсан тухай мэдэж авсан гэх яриа бол элбэг байдаг. Тухайлбал, бөөгийн уг нь тодорч байсан ЭБ гэх 20 хараахан хүрээгүй залуухан хүү 2007 оноос бөөгийн өвчин болон харуй бүрий болмогц, хий юмс үзэгдэж сонсогдож, зүүд зөнд учир гаран улмаар 2008 оноос бөөгийн уг авахад эцгийн талаасаа бөө болон ламын уг удамтай гэж мэдсэн байдаг. Тэрээр эцгээсээ тусдаа өссөн тул уг удмаа мэдэхгүй байсан бөгөөд Багануур дүүрэгт аж төрж байсан төрсөн эцгээ олж уулзан энэ тухай лавлахад тэдний удам бөө байсан тухай огт мэдэхгүй байсан. Харин удалгүй ЭБ удмын гэх таван онгод буулгаж эцгийн талын буюу өнөөгийн Говь-Алтай аймгийн Төгрөг сумын нутагтай нэг лам, хоёр удган, нэг заарингийн онгод орсон байдаг. Энэ мэтчилэн хожим уг удам нь тодорсон гэх зүйл нэлээдгүй байна. Хэрвээ ийнхүү бидний ойрын өвөг дээдэс үл мэдэх дээхэн үеийн бөөгийн уг удам залгаж байна гэсэн үг. Ингэвэл судалгааны дараагийн түвшний асуулт бол дээхэн үеийн буюу бидний үеэс хол тасарсан удмын онгодууд улаачаа товлон бөөгийн биед бууж байгаа юм бол чухам хэдий үеийн онгодууд ийнхүү сэргээд байгааг тодруулах шаардлагатай. Судлаач О.Пүрэв бүтээлдээ онгодын насны тухайд хамгийн өндөр настай нь буюу олон жилийн өмнө хүн байгаад өөд болсон нь 200-300 жилийн өмнөх хүмүүс байна гээд харин түүнээс өмнөх үеийн бөө нэр тэдний онгод болсон сүнснүүд хэрхэсэн байж болох тухай асуудал дэвшүүлсэн байдаг (Пүрэв 1998: 312-313). Гэтэл өдгөө энэ асуултын хариулт гарч ирж байх бөгөөд одоо бууж байгаа онгодуудын дотор Батмөнх Даян хаан⁶, Чингис хааны үеийн онгодууд тэр бүү хэл XIII зуунаас хол өмнөх үеийн онгодууд бууж байна. Тухайлбал, бөө ЭБ-ийн хамгийн өндөр настай Ж гэгч онгод нь 1300 жилийн өмнө удган байгаад

⁵ Удган Ө-гийн түшээ Д-ээс 2011 оны 12 сард авсан мэдээлэл.

⁶ Заарин ЭТ-ийн толгой онгод нь өөрийнхөө хүн байх үеийг “Батмөнх Даян хаан гэж хаан байх үед би амьдарч байлаа” гэж өөрийгөө танилцуулж байсан (2011 оны 7 сар).

онгод болсон гэж өөрийгөө танилцуулж байсан. Түүнчлэн мөн дээр дурдсан удган Ө-гийн түшээ Д-ийн уулзаж байсан хамгийн өндөр настай онгод “хүн үүсч байх үед байсан гэж өөрийгөө танилцуулж байсан” гэж өгүүлж байлаа. Өөрөөр хэлбэл, онгодын нас өдгөө мянга мянгаар тоологдох болжээ. Хэрвээ мянга мянган жилийн өмнөх бидний өвөг дээдсийн бөөгийн уг удам сэргэж өдгөө улаачаа нэхэж байгаа бол бидний олонх нь бөөгийн удамтай байх нь зүйн хэрэг болж таарна. Эртний судлалын олон баримт сэлтээр зөвхөн монгол төдийгүй хүн төрөлхтөн чулуун зэвсгийн үеэс бөөгийн уламжлалтай байсан тухай мэдээ баримт чамгүй байдаг (Walter 2004: xv). Ингэж үзвэл чулуун зэвсгийн үе дэх бидний өвөг дээдэс олонх нь бөөтэй байсан байх боломж тун өндөр болох нь тодорхой юм. Энэхүү бөөгийн эртнээс улбаатай удам өдгөө олон бөө төрөөд байгаагийн тайлбар болж байна. Тэгэхлээр бид цаг хугацаа, орон зайн хувьд маш өргөн хэмжээний алслалд оршиж байгаа шүтлэг мөргөлийн нэгэн үзэгдлийг судалж байна гэсэн үг. Нэгэнтээ ийм өргөн хэмжээг хамрах тул зөвхөн тооны олон байхаас гадна түүнийгээ дагаад төрөл зүйлийн олныг бид бас дагуулж байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал бид саяхан бөө удамтай байдаг тухай өгүүлсэн боловч энэ бол бөөг тодорхойлох хэмжүүр биш юм. Бөөг удамтай удамгүйгээр нь юмуу эсвэл юу буулгаж оруулж байгаагаар нь олон төрөл зүйл болгон ялган тодорхойлж болно. Удамгүй бөөг Дархадууд *зэлэг бөө* гэдэг байсан тухай судлаач С.Дулам өгүүлсэн байхад (Дулам 1992), Японы судлаач И.Шимакура хэрхэн бөө нэр тасарч бүдэгрэн тодорхой бус болсон уг удмаа дахин сэргээж шинээр бүтээж байгаа тухай (Shimamura 2004: 210) судалсан байна. Сүүлийн үед ч-ялгагүй өөрийн удмын онгодыг биш харин лус савдаг, албин тийрэн буулгадаг олон бөө бий болсон байна. Эсвэл өөрөө бөөгийн удамгүй гэсэн атал өрөөл бусдын онгодоос гуйж мөргөж байж ямар нэгэн хий хийсгэлэн зүйл өөртөө оруулдаг болсон жишээ баримт бас байна. Бүр цаашлаад, ураг удам дагадаг онгодын ёсноос гадна ураг удмын хэлхээнээс ангижирсан тэнгэрийн бөөгийн ёсонд бол улаачид удам дамжин тэнгэр бууна гэж үгүй ажээ. Харин тэнгэр буух улаачаа олны дотроос аль сайн сайхан, хүчтэй чадалтайг өөрөө товлон сонгодог гэдэг. Өөрөөр хэлбэл, тэнгэр буулгах улаач удам судартаа бөө, онгодтой байсан байх албагүй ч байсан байлаа гэсэн удмын онгодыг давсан тэнгэр бууж ирдэг гэсэн үг.⁷ Үүнээс үзвэл бөө орж байгаа хий хийсгэлэн зүйлээр төрөл зүйл гаргавал албин тийрэн буулгадаг, лус савдаг буулгадаг, удмын онгод эсвэл удмын бус тэнгэр буулгадаг⁸ гэхчилэн олон анги ялгаа гарч ирж байна.

⁷ 34 настай С хэмээх залуу тэнгэр буулгахаар тодорсон бөгөөд түүнийг тодруулсан А хэмээх заарингийн Д хэмээх онгод энэ тухай өгүүлсэн (2010 оны 11-12 сар, 2011 оны хаврын эхэн үед уулзаж ярилцсан тэмдэглэл).

⁸ О.Пүрэв бүтээлдээ тэнгэр буулгадаг тэнгэрийн бөө цөөхөн байдаг тухай өгүүлжээ (Пүрэв 1998: 309).

Үүнээс үзвэл бид энэхүү хувь бодгал бүрийн (individual) өвөрмөц онцлогоор ялгарч байдаг маш олон янзын төрөл зүйлтэй үзэгдэлд “бөө”, “бөө мөргөл”, “бөөгийн шашин” гэх мэтийн нэр өгөөд өнөөгийн өөрсдийнхөөрөө ойлгож, тодорхойлж “бөө” гэдэг нэгэн бүхэл цогц ухагдахууныг бүтээж байдаг гэж болно. Бөө гэдэг бол тодорхой нэг зүйл биш харин олон янзын ухагдхууны бүрдэл гэдгийн нэгэн тодорхой жишээ бол бөөгийн хувцас хэрэглэл, гүйцэтгэдэг зан үйлийнх нь давтагдашгүй ялгаанууд юм. Энэ ялгаа нь, дээр дурдсан оруулж буй хий юмсын ялгаатай шууд хамааралтай. Нэгэнтээ бөөгийн хувцас хэрэглэл гэдэг бөөгийн гэхээсээ илүү бөөд бууж буй хий юмны эдлэл хэрэглэл мөн тул тэр хэн байхаас юу хэрэглэх ямар дээл хувцас өмсөх нь хамаарч байдаг. Тухайлбал, хамгийн түгээмэл ил харагдахаар нь бөө дээлийг аваад үзвэл тэрхүү бөө дээл яг тэр хэлбэр, хэмжээ, өнгө, хийсэн эд, дээлэн дээрх зүүсгэл сэлтээрээ дахин давтагддаггүй. Бүр зарим тохиолдолд бөө дээлгүй эс бөгөөс баатар дээл, лам дээл өмсөж онгодоо буулгадаг юм уу бүр нүцгэн онгодоо буулгасан⁹ тохиолдол ч байдаг. Тухайлбал дээр танилцуулсан халх бөөгийн удам залгаж байгаа ЭБ улаан орхимж бүхий шар өнгийн дээл өмсөж онгодоо буулгадаг бөгөөд 25-ныхаа жил дээр онгодууд нь бөө дээлээ хийлгэнэ гэж ярьж байсан. Түүний таван онгодын дотор нэг хувилгаан лам хүний онгод байдаг бөгөөд түүнийг даган одоохондоо лам дээлэн дээр нь бусад дөрвөн бөөгийн онгодууд нь бууж байгаа гэж тайлбарлаж байсан.¹⁰ Мөн сартуул угсааны Ч гэх хорь гаран насны зааринд буудаг толгой онгод нь баатар хүн байсан гэх бөгөөд улаачдаа том ширэн бүстэй баатарын дээл хувцас өмсгөдөг.¹¹ Хувцас хэрэглэл гэдэг бол маш олон учраар бөө болон онгодыг хамгаалах агуулгатай байдаг бөгөөд харин онгод тэнгэрийн эрэмбэ суудал дээшилж хүч чадал ихсэх тусам энэ мэтийн хувцас хэрэглэл огт хэрэг болохгүй байх боломжтойг онгодууд хуучилж байсан тухай удган Ө-гийн түшээ Д өгүүлж байсан.

Үүнээс үзвэл бөө гэдэг маш олон тоотой байхын хажуугаар бас таан таамаглаж, тодорхойлж боломгүй, тогтвортой бус шинж чанарыг агуулсан олон төрөл зүйлтэй болж байна. Бөөг бууж байгаа хий хийсгэлэн зүйлээр нь ангилвал албин тийрэн буулгадаг, лус савдаг газар усны эздийг буулгадаг, удмын онгод буулгадаг, удмын бус тэнгэр буулгадаг гэхчилэн олон зүйл болж болох бол өмсгөл хувцсаар нь тухайлбал тэр олон янзын бөө дээлээр нь ангилж болохоос гадна тодруулбал лам дээлтэй, бүр дээл хувцасгүй гэж хүртэл ангилж болох болоод байна. Ийм тохиолдолд судлаач юм уу өөр хэн ч бөөгийн

⁹ Удган Ө-гийн түшээ Д-ээс 2011 оны 12 сард авсан мэдээлэл.

¹⁰ 2008 оны 6-10 сарын үест уулзан тэмдэглэж авсанаас иш татав.

¹¹ 2011 оны 5 сарын эхээр УБ хотоос баруун зүгт 40 км-ийн зайтай байдаг Бурхантын хөндийд сартуулын заарин А-гаар ахлуулсан бөө босгох түүдэгийн ёслолд оролцон тэмдэглэж авсанаа эх сурвалж болгон хэрэглэв.

хувцас хуяг ийм тийм байдаг гэж дүгнэн хэлэх нь бүү хэл бөө гэдэг тусгай өмсгөл хувцастай байдаг ч гэж ноттой тодорхойлох боломжгүйд хүргэж байгаа юм. Эндээс үүдэн буй болж болох гол маргаан бол албин тийрэн, газар усны эзэд буулгаж байвал эс бөгөөс ийм тийм хуяг хувцасгүй бол бөө мөн биш гэсэн зөрчил юм. Тухайлбал, 20 гаранхан настай халх угсааны удган болсон А бөө болоод хоёр, гуравхан жил болж байгаа боловч сэтгэл санаа нь тогтохгүй, бодох сэтгэх нь удаашрах болж¹² өөр халх угсаатны 25 орчим насны заарин ЭТ-ийн онгодоос лавлавал удмын онгодгүй уулын савдаг наасан бөө болох учиргүй хүн байжээ гэж оношлогдсон байна¹³. Иймээс эрдэм шинжилгээний түвшинд бөө болон бөө мөргөлийг тодорхойлох; бөө, бөө мөргөл, бөөгийн шашин гэж юу вэ гэдэг асуултанд хариулахыг оролдохын өмнө хариулах боломжтой эсэхийг нягтлан үзэх нь зүйд нийцэх мэт санагдаж байна.

2. Бөө нэрийн ёс зүй

Бөө болон бөө мөргөл хэмээх нэгэн тодорхой барьцтай зүйл байдаггүйн өөр нэгэн баримт бол олон төрлийн бөө гэдэг ойлголтоос урган гарч ирэх тэдний баримтлах олон түвшний ёс зүйн хэм хэмжээ юм. Ёс зүйн хүрээнд олон сэдвийг хөндөж болохын дотор энэ хэсэгт бид өдгөө ихээхэн яригдах болсон бөө нэрийн авдаг өргөл барьц болон бөөгийн зан үйлд архи сархад хэрэглэх явдал хэрхэн ёс зүйн асуудал болон хувирч байгааг авч үзэх болно. Олон бөө, бөөгийн дотор байгаа олон төрөл зүйл бүр бас тус тусдаа янз бүрийн бөө нэрийн ёс зүйн хэм хэмжээг илэрхийлж байдаг. Харин сүүлийн үеийн мэдээ сэлт баримт нотолгоогоор бол энэ ялгаа мөн л дээр өгүүлсэн бөө болон тэдний онгод тэнгэрийн эрэмбээс шалтгаалж байдаг гэж тайлбарлаж болох бололтой. Энэ тухай тус хэсгийн төгсгөлд дэлгэрэнгүй авч үзэх болно.

Бөө нэр өөрсдийгөө олон түмний сайн сайхны төлөө үйл бүтээгчид хэмээн нэрлэн тодорхойлох нь түгээмэл бөгөөд энэ нь тэдний өргөн хэрэглэх болсон “бөө гэдэг бол зовлонтны жолооч, золгүйтний хэлмэрч” гэдэг үгнээс тодорхой байдаг. Түүнчлэн бөө нэрийн үйл хэргийг бүхэлд нь шашин (Buyanbatu 1985, Пүрэв 1998) гэж үзвэл түүнийгээ дагаад тэд өргөл барьц, ашиг орлого, мөнгө зоос, эд агуурсанд дулдуйдалгүй хэн хүнийг зовлон бэрхшээлээс нь салгаж өгдөг хариу нэхдэггүй буянтан байх учиртай мэт ойлголт аяндаа бий болж байдаг. Тийм ч учраас Буриад бөөгийн *шахан* буюу андгай тангаргын үгэнд “сэтэрхий тэвнэ, сиймхий хадаг” барьсан байсан ч тэр хүнд бөөлж өгөн туслах учиртай (Гантогтох 1997: 37-44) гэж гардаг. Энэ ёс

¹² Удган А-тай 2011 оны 4-5 сард хэд хэдэн удаа уулзаж тэмдэглэж авсанаа эх сурвалж болгон ашиглав.

¹³ Удган А заарин ЭТ-ийн онгодтой 2011 оны 7 сарын эхээр уулзаж өөрийн хэрэг явдалын талаар лавлаж дээрх мэдээллийг авсан байна.

зүйн хэм хэмжээ өдгөө үйл болгонд таарсан зах зээлийн ханш бий болсонтой¹⁴ шууд эсрэгцэж байдаг. Өргөл барьцтай холбоотойгоор одоо бидний мэдэж байгаагаар наад зах нь гурван зүйлийн тохиолдол байна. Нэгд, үйл хийлгэж байгаа хүний сүсэг, боломжоос хамааран өгсөн барьцыг нь авах тохиолдол, хоёрт бөө юм уу онгод нь тусгай ханш хэлж нэхэх тохиолдол, гуравт, ханш ч хэлэхгүй, бас өгсөн зүйлийг нь огт авахгүй байх тохиолдол аль аль нь байдаг бөгөөд нэг бөөд гурван тохиолдол илэрч ч болох юм. Эндээс үүдэн мөн л бөө нэрийн хооронд ялгаа бий болж адил бус байдал гарахаас гадна бөө нэрийн дотор ч зөрчил зөрөлдөөн гарч байдаг. Харин судлаачдын хувьд өргөл барьц авч байгаа бол муу аваагүй бол сайн, эсвэл авч байгаа нь бөө биш авахгүй байгаа нь жинхэнэ бөө гэж хандахын оронд ямар тохиолдолд авч байна, яагаад авч байна, яагаад авахгүй байна гэсэн ялгааны тухай лавлан судлах нь зүйтэй. Тиймээс энд юуг ямар ханшаар үйлддэг тухай олон баримт дурдахаас өмнө яагаад өргөл барьц авах эсвэл яагаад авахгүй байх учиртай тухай бөө нэр болон тэдний онгодуудын хэрхэн тайлбарлаж байгааг дэлгэн өгүүлье.

Хэд хэдэн бөө нэр болон тэдний онгодын өгүүлж байгаагаар бол өргөл барьц авах эсэх нь онгодын суудал, эрэмбээс буюу гэгээрлийн түвшингээс хамаардаг ажээ. Харин онгод тэнгэрийн хувьд биш, албин тийрэнгийн тохиолдолд бол улаачаа эд агуурсанд умбуулж баяжуулж байдаг ялгаатай байдаг. Энэ тухай бид анх 2010 оны намар Ө удганы Т гэх толгой онгодтой хөөрөлдөж хэдэн зүйл тэмдэглэж авсан юм. Т онгодын хэлж байгаагаар бол онгодууд хүний ертөнцийн бодлог мөн чанараас ангижран бодот зүйлийн хоосон мөн чанарыг шүтэж дэвших гэж зорьж байдаг ажээ. Тиймээс хүнд үйл хийж өгөөд өргөл барьц авах нь бүү хэл хүний бодлог мөн чанарт хамаатай үйл хийж өгөхөөс ч цааргалж байдаг. Биднийг байх үед нэгэн эр уул уурхайн ажил бүтээлгэх тухай асуухад Т онгод “би ийм хүний үйл хийдэггүй” гэж цааргалсан бөгөөд өөрөөсөө дор эрэмбэтэй Д гэх онгодоо нэрлэн түүгээр хийлгэ гэж байсан юм. Хожим бид түүнээс “та тэгээд хүний үйл хийхгүй гэхээр өөр ямар үйл хийдэг хэрэг вэ гэж асуухад” “би төрийн үйл болон энэ бөөрөлдийн [гараг/дэлхий] үйл хийдэг” гэж хариулж байсан. Түүнээс учрыг нь лавлавал “бид өөрсдөө хүний бодит мөн чанараас ангижрах гэж явж байж бодит хоосон чанартай юмны төлөөх үйл хийгээд байвал таарахгүй биз дээ” гэж хариулж байсан. Үүнээс үзвэл онгодын эрэмбэ суудал дээшлэх тусам

¹⁴ Ханш бий болсон нь олон баримтаас нэгэнт тодорхой тул энд тодорхой жишээ болгон хэн нэгнийг юм уу аль нэгэн бөөгийн төв байгууллагыг дурдалгүй үлдээлээ. Мөн судалгаанд эх хэрэглэхүүн болох мэдээ мэдээллийг бий болгож байгаа бөө нэр, хувь хүмүүсийн нэр хүнд, үзэл бодол, ашиг сонирхолд таатай бус нөлөө үзүүлэхгүй байхын үүднээс жишээ баримт болгон тодорхой хүн байгууллагыг нэрлэлгүй орхих нь зүйтэй гэж үзлээ. Харин энэ тухай МУИС-ийн Нийгэм, соёлын антропологийн тэнхимд оюутан Б.Удвал *Бөө нэрийн эдийн засаг* сэдвээр 2008 бакалаврын дипломын ажил бичсэн.

тэдний өөрсдийнх нь хэлж байгаагаар бол гэгээрэх түвшин дээшилж өргөл барьц авдаггүй болдог бололтой. Харин үүний яг эсрэгээр онгодын эрэмбэ суудал доошлох тусмаа хүний ертөнцийн бодлог материаллаг зүйлд шүтэж байдаг бололтой. Үүнээс арай ялгаатай боловч бас зарим талаараа төстэй хариултыг заарин А-гийн Д гэх толгой онгод өгүүлж байсныг 2010 оны өвөл тэмдэглэж авсан билээ. Түүний тайлбарласнаар бол онгодууд эрэмбэ суудлаараа тэнгэрээс хүч авдаг эсвэл газраас хүч авдаг гэж ялгардаг ажээ. Их өндөр тэнгэр эрэмбэтэй онгодууд юм уу тэнгэрүүд гагцхүү Мөнх тэнгэрээс хүч авдаг тул тэд өргөл барьц мэтийн зүйлээр дамжуулан газар болон хүмүүний ертөнцөөс хүчээ сэлбэн авах шаардлагагүй байдаг ажээ. Харин ийнхүү Мөнх тэнгэрийн оронд ойртоогүй суудлын эрэмбэ дор онгодууд тэнгэрээс хүч авдаггүй тул гаргаж байгаа хүчээ газар болон хүмүүний ертөнцөөс буцаан авч сэлбэж байдаг гэнэ. Ийнхүү газраас хүчээ сэлбэхдээ хүмүүсийн сүсэг бишрэл, өргөл барьц сэлтээр дамжуулан олж авдаг ажээ. Ямарч үйлийг тодорхой хэмжээний хүчээр бүтээх бөгөөд тэр хүч хаанаас хэнээс гарах вэ гэдэг бол гол асуудал болдог байна. Тэнгэрээс хүч авдаггүй онгодууд үйлийг зөвхөн өөрийн хүчээр бүтээдэг бөгөөд зөвхөн өөрөөсөө л хүч гаргаад байх юм бол аажмаар сульдан доройдож мөхөлд хүрэх аюултай байдаг байна. Тийм учраас гаргасан хүчээ үйл бүтээлгэж байгаа хүнээс ямар нэгэн хэмжээгээр өргөл барьцаар дамжуулан олж авдаг гэсэн тайлбар хэлж байлаа. Д онгодын хувьд бол үйл бүтээх хэрэгт нийт зарцуулах хүчний талыг өөрөөсөө гарган тусыг бүтээж харин үлдсэн хагасыг нь үйл бүтээлгэж байгаа хүнээс өргөл барьц болгон гаргуулж авдаг гэж учирласан юм. Ийнхүү өөрийн болон үйл хийлгэж байгаа хүнээс авсан өргөл барилаа нийлүүлэн цааш нь Мөнх тэнгэрт мэдүүлэн үйлээ даатгаж өргөл болгон өгдөг ажээ. Үүнтэй ихэд төстэй хариултыг ЭТ заарингийн тэргүүн онгод улаачдаа тайлбарлан хэлж байжээ. Хөрстийн мөн чанараас алслан холдохыг зорьж байж хүмүүсийн өгсөн өргөл барьцыг аваад байх юм бол тэр зорилгодоо яаж хүрэх билээ гэж өгүүлж байжээ. Учир нь нэгэнтээ тэнгэрээсээ авах юмаа авч хүртэх зүйлээ хүртэж байгаа хөрстөөс өргөл барил сэлтийн зүйл авах учиргүй гэсэн санаа хэлсэн байна. Үүнээс үзвэл өргөл барьц гэдэг бол нэгэн ёсондоо онгодын хүчтэй шууд холбогдох зүйл болж таарах бөгөөд харин өргөл барьцын хэмжээг үнэн хэрэгтээ бөө биш харин бөөд орж байгаа онгод нь тогтоох учиртай бөгөөд энэ бүхэнд энгийн эд агуурс мөнгө хөрөнгийн учраар илүү нарийн үйлийн үрийн агуулгатай байдаг бололтой.

Энэ мэтчилэн өргөл барьц, мөнгө төгрөг авах тухай асуудал бөө нэрийн хувьд онгодынх нь суудлын эрэмбэтэй хамаатай байдаг шиг архи сархад хэрэглэх явдал мөн төстэй утга учиртай байдаг байна. Бидний мэдэхээр бөө нэр болон онгодууд сархад хүртэх явдал түгээмэл байсан. Тухайлбал, Буриад

бөөгийн ёсонд “хатуу хар”, дархадууд “шимийн бараан” гэхчилэн архийг олон янзаа нэрлэн хэрэглэдэг байсан (Бум-Очир 2002: 45-46). Гэтэл өдгөө нэг бол сархад ихээр хүртдэг эсвэл огт хүртдэггүйн хооронд олон зүйлийн ялгамжаатай бөө нэр бий болоод байна. Үүнээс болоод олон нийтийн дунд зарим бөө нэр архи сархад ихээр хэрэглэж байгаа тухай ёс зүйн сэдэвтэй маргаан бий болсон бөгөөд энэ нь бөө нэр дотороо олон янз байдгийн өөр нэгэн жишээ болж болох юм. Энэхүү адил бус байдал мөн л өмнө дурдсан гэгээрлийн түвшинтэй холбон тайлбарлагдах бөгөөд онгод нь хүмүүний бодлог мөн чанараас хагацах тусмаа сархад хэрэглэхээ больдог бололтой. Дээр дурдсан А заарингийн Д гэх онгод сархад хэрэглэх эсэх хэрэг мөн л онгодынх нь суудлын эрэмбэ чадалтай шууд хамаатай зүйл болох тухай өгүүлж байсан. Архи гэдэг бол нэг талаас идээний дээж ундаа боловч нөгөө талаасаа онгод болон бөө нэрийн хувьд муу сэвийг зайлуулах нэгэн ёсны зан үйлийн утгатай ажээ. Ямар нэгэн үйл хийгээд ялангуяа харын гэх хатуу хүтүү үйл гүйцэтгэвэл үүнээс үүдэн бөөд наалдаж үлдэж болохуйц сэв хэмээх бузар буртаг, буг зэтгэрийн зүйлийг цэвэрлэн ариун болгох чанартай байдаг. Тиймээс хатуу үйл хийхийн өмнө болон хийж дуусаад бөө бага сага сархад хүртэн бие сэтгэлээ сүнс сүлдээ ариутгахаас гадна бусад олон тохиолдолд эд зүйл дээрээ дусаан ундаалах мэтээр нэгд цэвэрлэн нөгөөтэйгүүр хамгаалж байдаг. Энэ бол сархадын бөөгийн зан үйлд хэрэглэгддэг нэгэн үүрэг байдаг бол харин зарим залуу онгод эсвэл дан ялангуяа албин тийрэнгүүд архийг согтууруулах утгаар бас хэрэглэж байгаад шүүмжлэлтэй хандаж байсан. Гэтэл зарим онгод тэнгэр, бөө нэр сархадыг дээрх хоёр учрын алингаар нь ч сархадыг эс хэрэглэж байдаг. Тухайлбал энд дурдаад байгаа А заарингийн шавь болох Ду удганы онгодууд сархад огт хэрэглэдэггүй. Үүний учир нь А заарингийн мөнөөх онгодын тайлбар ёсоор бол сэвээ архиар биш харин Мөнх тэнгэрээс хүч аван гаргадаг учир сархад хэрэглэх шаардлага нэгэнт үгүй болсон хэрэг гэж байсан. Харин Д онгод бол өөрөө сархадыг заслын утгаар бага сага хэрэглэх бөгөөд харин өөрийнхөө дор эрэмбэд буй бусад онгодуудаа аль болох сархад хүртэхгүй байхыг зөвлөж, сархад нэхэж уугаад байгаа онгодуудаа торгон шийтгэж бөөд буулгахгүй байх эсвэл буусан ч сархад нэг жижиг тагшаас илүү хүртэхгүй байхыг бөөгийн түшээд даалгасан байсан.

Дээрх жишээ баримтууд болон өдгөө монголын нийгэмд түгээмэл болсон олон баримтаас үзвэл олон зүйлийн бөө нэр харагдаж байна. Энэ олон зүйлийн бөө гэхээсээ илүү тэдний ойлгож байгаагаар бол олон түвшин бий болоод байгаа нь бөө нэрийг өөр өөр болгож байна. Нэгд, өргөл барьц юм уу мөнгө төгрөг их хэмжээгээр нэхэж авдаг, архи сархад ихээр хэрэглэдэг хэсэг бүлэг байх бөгөөд тэднийг албин тийрэн гэх бөгөөд ийм бөө нэрийг голдуу албинтаж тийрэнтсэн гэдэг. Гэтэл тэднээс арай ондоо гэх юм уу эсвэл хүмүүний

мөн чанараас үл хагацсан архи сархадыг ундааны зориулалтаар тааваар хүртэж суудаг, тэнгэрээс хүч авч чаддаггүй тул хүмүүсийн өргөл барьцаар хүч авдаг суудлын эрэмбэ дортой онгодууд болно. Дараа нь, гэгээрэх зам мөрийг даган сархадыг ариусгах зан үйлийн чанартай зүйл болох агуулгаар л хэрэглэдэг, өргөл барьц авсан ч Мөнх тэнгэртээ барьдаг, аль болох хүмүүний бодлог хоосон мөн чанартай үйл хийлгүй энэ хүмүн төрөлтөнд болон төр улсад нэмэр болох үйл хийдэг гэх өндөр эрэмбэтэй онгод бүхий бөө нэр байх бөгөөд үүний жишээ нь дээр дурдсан удган Ө, заарийн А нар байж болох юм. Харин дараагийн түвшинд өргөл барьц огт авдаггүй, сархад огт хэрэглэдэггүй тэнгэр гэж нэрлэгдэх онгодууд байж болох бөгөөд үүний тодорхой жишээ А заарингийн шавь Ду удган болон ЭТ заарингийн тэнгэрийн онгодууд юм. Бид Ду удгантай 2011 оны хавар таван сард хэдэнтээ уулзаж байсан бөгөөд онгод нь хүн хадаг, мөнгө барьвал эргүүлээд өгчихөж байсныг олонтаа үзсэн билээ. Түүний багш болох А заарин болон түүний онгод ч Ду удганы онгодыг тэнгэр гэх бөгөөд өөрөөс нь хол өндөр эрэмбэтэй гэдгийг олонтаа хэлж байсан.

3. Бөө нэрийн доторх зохион байгуулалт ба дахин дэлгэрэлтийн мөн чанар

Өмнө өгүүлсэн хэсгүүдэд бие биенээсээ илт ялгарах өөр өөрсдийн онцлог бүхий, нэгдсэн тодорхойлолтод үл багтах маш олон төрлийн хувь бодгалиуд байдаг тухай өгүүлсэн бол харин энэ хэсэг тэдгээр бөө нэрийг бүгдийг нь биш юмаа гэхэд хэсэг бүлгээр нь ч юмуу хэрхэн нэгтгэж, нэгэн зохион байгуулалтанд оруулж холбон сэтгэж байгаа талаар өгүүлэх юм. Өөрөөр хэлбэл, энд бөө нэр зөвхөн тархай бутархай, хоорондоо холбоогүй олон төрлийн үйл бүтээгч, арга ширгэ хийгчид гэж үзэж болохоос гадна бас тэднийг нэгтгэн холбосон нийтлэг шинжтэй ерөнхий ухагдахуун бас байгааг авч үзэх юм. Бөө нэр гэдэг олон хувь бодгалиуд болон тэдэнд бууж байгаа онгод сахиуснууд хоорондоо ямар ч уялдаа холбоогүй, эх захгүй олон хүн юмуу онгодууд биш юм. Харин тодорхой шаталсан захиргаа, суудалын эрэмбэ дараа бүхий зохион байгуулалтад байдаг, эх захтай зүйл болж таарах бөгөөд энэ бол “бөө”, “бөө мөргөл”, “бөөгийн шашин” гэх энэ зүйл дотор дахин бүтээгдэж бий болж байгаа урьд өмнө тодорхойгүй байсан өөр нэгэн онцлог юм.

1990-ээд оноос эхлэн өдгөө хүчтэй үргэлжилж байгаа бөө нэрийн дахин сэргэлтийг заарин ЭТ-ийн тэргүүн онгод “бар жилийн барьцалдаан, туулай жилийн тунаан” гэж тодорхойлон хэлж байжээ. Энд гарч байгаа бар жил гэдэг бол 2010 харин туулай жил нь 2011 он байдаг. Энэ бол нэг онгод, нэг бөөгийн хэлж байгаа зүйл бус харин өөр нэлээд хэдэн эх сурвалжид бас давтагдаж байгаа санаа юм. Тухайлбал дээр гарсан А заарингийн тэргүүн онгод үүнтэй төстэй зүйл өгүүлж байсан. Тэрээр бар жил хүртэл албин тийрэнгүүд олширч, шинэ бөө нэр ихэд самууран, олон уг удмын онгодууд сахиусууд үйлээ бүрэн

гүйцээж улаачаа бууж чадалгүй сэвтэн хүч мөхөсдөж, хоорондоо дур зоргоор зөрчилдөн хатгалдаж хэн нь хэн юу нь юу болох нь үл мэдэгдэх үймээнтэй үе байна гэсэн санаа хэлж байсан. Харин энэ эмх цэгцгүй байдал туулай жил гармагц хумигдан цэгцээ олж албин тийрэн болон тэдний хорлолд автсан эсвэл шудрага бус зүйл үйлдсэн бөө нэр болон онгодууд гэсгээн шийтгэгдэж “жинхэнэ”, “чадалтай”, “зөв шудрага” бөө нэр болон онгодууд тунах үлдэх юм гэдэг. Туулай жилд *босох* (улаачдаа буух) өндөр эрэмбэ зэрэгтэй баатар дайчин онгод тэнгэрүүд шүүн цаазлах, цээрлүүлэн *цэвэрлэх* үйлийг гүйцэтгэх учиртай гэж өгүүлж байсан. Харин ийнхүү тунах цэвэрлэгдсэний дараа түүний удаах луу жилд буюу 2012 онд баатар жанжидын ахлаачид болох тэнгэр онгодууд болон тэнгэрүүд энэ хөрстөд улаачаа товлон бууж ирснээр энэ бөөгийн үйл шулуудан зөв зам мөртөө орж жинхэнэ бөөгийн ёс дэг бүрэн утгаараа тогтнох юм гэж тайлбарлаж байсан. Эндээс тодорхой харагдаж байгаа нэгэн чухал баримт бол сахиус, онгод, тэнгэр нэр улаачаа товлон хөрстөд буухдаа хүчийг илэрхийлэх суудлын эрэмбийн дэсийн дарааллаар бууж ирдэг гэсэн санаа юм. Өөрөөр хэлбэл, эхлээд дор эрэмбийн залуу онгодууд голдуу энэ хөрстөд бууж ирэн дараагийн жилүүдэд тэднийг ахлан буух дээрх эрэмбийн онгод тэнгэрийнхээ замыг засаж байдаг бололтой. Энэхүү бүтэн цогцлох мөн чанарыг бид удиртгал хэсэгтээ *овоо босох мэтээр хөгжснэс байдаг тогтолцоо* хэмээн зүйрлэн хэлсэн билээ. Ингэж үзвэл хожуу гарсан шинэ бөө нэр болон тэдний онгодууд өмнө бууснуудаасаа илүү өндөр суудалтай илүү хүчтэй чадалтай болж таарна. Энэ мөн чанарыг гэрчлэх мэт олон баримт байгаагийн дотор бидний судалгаанд хамрагдаж байсан 1990-ээд оны бөө нэр болон тэдний онгодуудын харилцан адилгүй ялгаатай байдал юм. Тухайлбал, түүхч бөө судлаач асан О.Пүрэв бүтээлдээ онгодын тухайн цагт уулзаж байсан онгодуудынхы насны байдлыг судалсан байдаг. Онгодын насыг урьд төрөлдөө бөө хүн байсан цагаас хөөн тооцож хамгийн эртдээ 250 жилийн өмнө байсан бөө хүний сүнс онгод болсон байна (Пүрэв 1998: 312-313) гэжээ. Үүнээс үүдэх дараагийн асуудал бол тэрнээс өмнө үед байсан бөө нэрийн сүнс онгод болж босоогүй хэрэг үү, хаачсан хэрэг вэ гэсэн санаа тухайн цагтаа илэрхийлж байсан. Гэтэл сүүлийн хэдэн жил буусан онгодуудын дотор өндөр настай тэргүүн онгодууд эрс олон болж байна. Тухайлбал энэ судалгааны ажилд хамрагдсан онгодуудын насыг авч үзвэл 2008 онд бөө болж байсан ЭБ-ийн хамгийн өндөр настай онгод нь 1300 жилийн өмнө байсан удган байсан бол Ө удганы тэргүүн онгод Д, А заарингийн тэргүүн онгод Д нэгэн үеийнх гэж өөрсдийгөө танилцуулах бөгөөд XIII зууны үед бөө хүмүүс байсан гэдэг. ЭТ заарингийн толгой онгодын хувьд бол дээр намайг бөө хүн байх үед Батмөнх Даян хаан гэж байлаа гэж хариулж байсан юм. Ингэж үзвэл тэрээр харьцангуй залуу онгод болох боловч онгодын насыг тоолох зүгээр хүн байсан үеэс нь

хойш авч тоолохоос илүү нарийн зүйл гэж онгодууд хэлж байдаг. ЭТ заарингийн энэхүү онгодын хувьд гэвэл хамгийн сүүлд бөө болж төрөхдөө тэр үед байсан болохоос биш түүнээс өмнөх төрөлдөө өөрөө бас онгод байсан гэдэг. Ингэж үзвэл онгод хүмүн болон мэндэлдэг гэсэн үг бөгөөд харин түүний насыг хүн болохоос өмнөх төрөлдөө онгод байсан хугацааг нь бас оруулах учиртай болж таарна. Юутай ч олон баримтаар харьцуулж үзвэл өргөл барьц авдаггүй, архи сархад хэрэглэдэггүй тэнгэрийн онгодууд өндөр эрэмбэ суудалтай болох нь илэрхий бөгөөд харьцангуй хожуу буюу сүүлийн таван жилийн дотор тэр дундаа ихэнх нь сүүлхэн үед улаачаа товлон хөрстөд бууцгаасан байна. 1990-ээд оноос бөө олшрох болсон цаг хугацааны алслалд аваад үзвэл бөө нэр болоод тэдэнд бууж байгаа хий хийсгэлэн зүйлсийн эрэмбэ суудал, хүч чадал улам өндөрсөж зан үйл, эдлэл хэрэглэл, ёс зүйн хэм хэмжээ нь хүртэл өөрчлөгдсөөр иржээ. Шаталсан захиргаа буюу эрэмбийн утгаар авч үзвэл овоо босгож байгаа мэтээр доод үе нь түрүүлж түүн дээр дараагийн үеийг нь босгох мэтчилэнгээр орой өөдөө ойртож байгаа бололтой. Тийм ч учраас луу жилд өмнөх онгодуудаас илүү өндөр суудалтай тэнгэрүүд буух жил гэж бөө нэр хүүрнэж байгаа тухай өмнө өгүүлсэн билээ.

Овооны олон үе мэт эрэмбэлэгдсэн бөө нэр болон тэдний онгодуудын харьцааг авч үзвэл үе бүр өөрийнхөө түвшинд болон доорх түвшиндээ л харьцаа тогтоох хүчтэй байдаг ажээ. Харин өөрөөсөө өндөр эрэмбийн онгод тэнгэрүүдтэй бол шууд харьцах хүчин чадал мөхөс байх бөгөөд өөрийн түвшинд ойр байгаа өндөр эрэмбэтэй чадан ядан харьцаж илүү өндөрсөх тусам харьцах нь бүү хэл олж харах мэдрэх оршин буй эсэхийг нь ч мэдэхгүй байдалтай байдаг байна. Үүнийг гэрчлэхүйц олон жишээ баримт байгаагаас дор өгүүлье. Нэгэн түгээмэл тохиолдол бол шинэ бөө босгоход багш шавь бололцох үйл юм. Онгодууд ирсэн зарим бөөгийн уг удамтай хүнийг “бөө болгож босгож чадахгүй юм байна, хүчин мөхөсдөх хүрэхгүй юм байна” гэхчилэн хэлэх нь цөөн бус тохиолддог. Чадна гэж хэлээд бөө болгох зан үйл гүйцэтгэсний дараа буруугаар эргэж үл бүтэх, босгосны дараа зөрчил үүсэх хэрэг чиг гардаг. Энэ бүхэн онгодын эрэмбээс үүдэх харьцаанаас шууд хамаатай байдаг. Тухайлбал, С гэгч гуч гаран насны залуу дээр гарсан А заарин дээр 2010 оны намар хүрч золгоод тэнгэр буулгах учиртайгаа мэдэж авсан байдаг. С туулай жилд бөө болж босох нөгөө баатар дайчин тэнгэрүүдийн нэгийг буулгаж туулай жилийн тунаанд үйл хийх учиртай гэж тодорсон юм. Харин А заарингийн тэргүүн онгод Д нь С-ийн тэнгэрийг буулгаж багшлахад эрэмбэ нь дордож хүч дутах тул босгож чадахгүй гэдгээ анх хэлж байсан. Гэтэл хожим нь ийм өндөр эрэмбийн тэнгэр босговол өөрийн эрэмбэ суудал ахин дэвшихэд хүртэл дэмтэй гал улаан тэнгэрийн гэх өөр нэгэн тэнгэр онгодуудын хучийг хавсран С-ийн тэнгэрийг босгох их үйлийг

гүйцэтгэхээр болсон. Ингээд товлосон ёсоор 2011 оны хавар 5 сард хээр гарч түүдэг асаан С-ийг тэнгэртэй нь учруулах үйлээ эхэлсэн боловч С-д онгод тэнгэр нь ойртож ирсэн боловч орж буулгүй учир битүүлэг шалтгаанаар үйл нь гүйцээгүй юм. А заарин болоод түүний онгод нь ч учрыг тайлж чадалгүй цаг цаас зарсан бүтэлгүй хэрэг болон төгссөн нь өдгөө олон хүнд тохиолдож байгаагийн л нэг жишээ юм. Ингээд ямар учир болсныг сурвалжлан А заарин болон түүний онгодууд нь ч өндөр эрэмбэтэй том тэнгэр буулгадаг болохыг нь нотлон хэлдэг өөр нэгэн бөө дээр очвол түүний тэнгэр нь “А заарингийн Д онгод ихэд дорвитой сайн заарин ч гэлээ энэ үйлд арай хүч хүрэхгүй байна, түүний хүч гэлтгүй миний хүч ч хүрнэ гэхэд хэцүү юм байна” гэж учирласан юм. Тэр бөө нэгэн зараалаа элж болгон С-д буух байсан тэнгэрийн босгоруу мордуулвал С-ийн А заарингийн онгодын заавраар бэлдүүлсэн олон хувцас хэрэглэл эд зүйлс буруу зөрүү зүйл их байснаас гадна гол учир нь С-ийн тэнгэр буух цаг хараахан болоогүй байна гэхчилэн учрыг нь тайлж өгсөн юм. Үүнээс үзвэл А заарингийн онгод эрэмбэ нь дордон С-ийн тэнгэр болон түүний зараа лусын удтай бүрэн шууд харьцаж чадаагүй тул үйл нь бүтээгүй ажээ.

Энэ бол түгээмэл тохиолддог шалтгаануудын нэг бөгөөд үүнийг бөө нэр “багшаа дарж буух онгод” гэдэг. Нэгэнтээ өмнө гарсан бөө нэр хожим гарч байгаа бөө нэрээсээ эрэмбийн хувьд дор байх бололцоотой юм бол багш бөө шавь бөөгөөс дор эрэмбэтэй байж болно гэсэн үг бөгөөд энэ хүчний харилцаа багш шавийн хооронд зөрчил үүсэх үндсэн шалтгаан болдог. Багш нь багш гэдэг утгаараа шавьдаа ахархах болоход шавийн онгодын эрэмбэ өндөр тул энэ байдлыг үл зөвшөөрөн зөрчил үүсдэг. Нэгэнтээ ийм учир байдаг тул багшгүй бөө болох сүүлийн үед нэлээд ажиглагдах боллоо. Энд дурдсан бөө ЭБ, удган Ө, заарин ЭТ нар бүгд багшгүйгээр бөө болон боссон байдаг. ЭТ-ийн онгодын тайлбарласнаар бол бүр эртдээ ийм шалтгааны улмаас багш гэж байгаагүй гэж өгүүлж байсан. Онгодынх нь хэлж байгаагаар эртдээ онгод нь улаачдаа хандан зүүд нойр, зөн совинд нь болон *гаамин барих* аргаар (бясалгалын аргаар) учир явдал хэрэг зоригоо өгүүлж улаачаа бэлдэж байж бөө болгож авдаг байжээ. Хувцас хэрэглэл эд зүйлээ мөн л энэ байдлаар улаачдаа бага багаар хэлэн бүх зүйлээ бэлдүүлж, улаачийнхаа сүнснийг ч онгод тэнгэрийн орноор авч зорчин танилцуулж байж бөө болох бэлтгэл хийлгэдэг байжээ. Ингэж аажмаар бэлдэж байж улаач нь онгод тэнгэр, эзэд савдаг, албин тийрэн мэтийн олон хий хийсгэлэн бүхнийг ялган таних чадвар сууж бэлтгэл хангадаг байна. Заарин ЭТ ялгаагүй багшгүй боссон бөгөөд дээр дурдсан энэ уламжлалт зарчмаар бөө болсон байдаг.

Энэ хэсэгт өгүүлсэн баримт сэлтээс үзвэл бөө нэр, онгод, тэнгэр нэрийн дотор нарийн чанд тогтсон эрэмбэ, хүчний шаталсан захиргаа байх бөгөөд энэ

эрэмбийг даган өдгөө бөө мөргөл сэргэж байгаа ажээ. Эрэмбийг даган сэргэж байгаа гэдэг нь овоо босгож байгаа зарчмаар эхлээд дор эрэмбийнхэн нь тогтнож дараагийн эрэмбийн онгодуудаа бууж ирэх замыг засах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй байдаг бололтой. Ингээд нэг эрэмбэ дээрэх эрэмбээ тэр эрэмбэ дараагийн дээдэх эрэмбээ буулгаж ирдэг тогтолцоо 1990-ээд оны үеэс хойш үргэлжилж байгаа бөөгийн уламжлал дахин сэргэх үйл явдал ажиглагдаж байна. Харин энэхүү эрэмбийг ялангуяа доод эрэмбийн онгодууд болон тэднийг буулгадаг бөө нэр мэдэхгүй, хүлээн зөвшөөрөхгүй (politics of recognition) (Taylor 1992) байх явдал гардаг нь эргээд бөө нэрийн дунд зөрчил бий болох үндсэн шалтгаан болж байна. Түүнчлэн олон төрлийн бөө, адил бус ёс зүйн хэм хэмжээ, ертөнцийг үзэх үзэлтэй байхын сацуу бас адил бус хүчний харилцаанд байдаг гэсэн санаа төрж байна. Урьд өмнө монгол бөө нэрийн дотор ийм нарийн чанд шаталсан захиргаа, эрэмбэ байдаг бөгөөд энэ эрэмбийн дагуу хэрхэн хүчний зохион байгуулалтад орсон байдаг талаарх мэдээ баримт хомс байсан гэж хэлж болно. Түүнчлэн бөө мөргөл сэргэх үйл явц энэ эрэмбэ дараатай ийнхүү нягт уялдаатайгаар явагдаж байгаа гэдэг баримт мөн л өдгөө судалгааны хүрээнд орж ирж байгаа шинэлэг эх сурвалж юм. Энд гарч байгаа өөр нэгэн сонирхолтой баримт бол бөөд багш гэж байх албагүй, зарим уламжлалд багшгүйгээр бөө болдог тухай хэд хэдэн удган заарингийн жишээ юм. Багшгүй бөө болно гэдэг бол нэг талаас эрсдэл их дагуулах хамгаалалтгүй байх аюултай боловч нэг талаас улаач болж байгаа хүн нөгөө талаас онгод тэнгэр нь сайн сахиж манаж бүтээдэг нэлээд чадалтай өндөр эрэмбийн онгод тэнгэрийн хийдэг үйл бололтой.

4. Зан үйл, шүтлэгийн олон уламжлал “бөөгийн” гэдэг нэр дор нэгдсэн ойлголт болсон байдал

Дээрх угсаатны зүйн (ethnographic) мэдээ баримтыг өргөн хүрээнд буюу нийгмийн тогтсон “бөө” гэдэг нэр томъёонд хязгаарлалгүй (reductionism) авч үзвэл хамгийн энгийн утгаараа олон зүйлийн зан үйл, шүтлэг мөргөлийн уламжлалууд болох юм. Өөрөөр хэлбэл, бидэнд буй “бөө” гэдэг нэрийн хүрээнд тогтсон ойлголт тодорхойлолтууд өнөөгийн бөө нэрийн дунд байгаа олон зүйлийн баримт сэлтийг тайлан тайлбарлахад хэтэрхий хязгаарлагдмал байна. Учир нь тэдгээр тогтсон ухагдахуунууд (dogma) бол судлаач болгон өөр өөрийн үедээ олдож байсан эх хэрэглэхүүн дээрээ үндэслэн гаргаж байсан тайлбарууд юм. Тухайлбал, бид 1990-ээд оны үеэс бөө судалж байхад бидэнд олдож байсан баримт сэлт одоо судлахад тааралдаж буй баримт сэлтээс эрс ялгаатай байгаа юм. Энэ бол магадгүй Банзарын Дорж ([1846] 1955),

Б.Я.Владимирцов (1916) нарын бөө судалж байсан цаг үе, газар орон хожим нь Б.Ренчин (1959, 1961, 1975), Ч.Далай (1959), С.Бадамхатан (1962) нарын судалж байсан үеийн бөө нэрийн байдал ондоо ондоо байсан гэсэн санаа болно. Ялангуяа, Монголын олон газар коммунист дэглэм хүчтэй болсон ХХ зуун тэр чигээрээ бөө судлахад эх хэрэглэхүүн хомс, улс төрийн үзэл сурталд ихэд автсан байсан гэх мэтийн олон шалтгаанаар судлах боломж бараг үгүй үе байсан гэж хэлж болно. Тийм учраас өнөөгийн бөө судлах эх хэрэглэхүүн тун арвин баялаг болсон энэ үед судлаад гарах дүн шинжилгээ өмнөх үед гарсан дүн шинжилгээтэй адилгүй байхаас гадна судлагдахууныхаа хүрээ хэмжээнээс хамаарч харьцангуй өргөн агуулгатай байх нь тодорхой юм. Орон зайн хувьд монголын газар газрын бөөгийн уламжлал ондоо ондоо байдаг нь маргаангүй бөгөөд нөгөө талд цаг хугацааны хувьд ч түүхэн үе болгонд бөө нэр бас адил бус чанарыг агуулж байдаг нь илэрхий болоод байна. Үүнээс үзвэл бөө нэрийн үндсэн мөн чанар бол хэзээ ч тогтсон нэгэн хэвээр байдаггүй байнгын бүтэж бүрэлдэн бий болох үйл явцад (in permanent process of under re-construction) байдаг төгсөшгүй шинээр цогцлон бүтэгч зүйл болж таарч байна. Хэрвээ энэ нь бөөгийн мөн чанар юм бол задлан шинжилгээний онол арга зүйн үүднээс түүнийг судлан тайлбарлах, тодорхойлон хүрээ хязгаар тогтоох ажил нэн бэрхтэй болж байгаа юм.

Яг л ийм учир шалтгаанаар урьд хожид гарсан судлаачдын болон ард түмний дунд бий болсон бөөгийн тухай тогтсон ойлголт тодорхойлолтууд туйлын үнэн зөв байж хаана ч хэзээ ч таарч байх албагүй тус тусын, үе үеийн, газар газрын бөөгийн тухай ойлголтын бүтвэр болно. Тухайлбал, дээрх угсаатны зүйн баримт сэлт бөө удам дамждаг, уг удмын онгод оруулдаг, өвөг дээдсийг шүтдэг, бүжиг дэвсэлтэй, дуудлага тамлагатай, эдлэл хэрэглэлтэй байдаг, багш шавь бололцож байж шинээр бөө төрдөг гэхчилэнгийн олон ойлголт заавал үнэн байж бөөг тодорхойлон хэмжих шалгуур баримжаа болж чадахгүйд хүрээд байгааг харуулж байна. Харин бодит байдал дээр бидэнд юу байна вэ гэвэл хоорондоо холбоотой, холбоогүй эсвэл адил төстэй байх албагүй маш олон янзын хувь бодгалиуд ба тэдний янз бүрийн зан үйл, эдлэл хэрэглэл, ертөнцийг үзэх үзэл, ёс зүйн хэм хэмжээнүүд л байгааг дээрх баримтууд харуулж байна. Үүнийг Данийн хүн судлаач М.Педерсон бөө мөргөл гэдэг бол юу байхыг нь таашгүй, юу ч байж болох тогтворгүй тодорхойгүй зүйл гэж үзсэн байна (Pederson 2011: 5-9).

Бид ийм олон өөр хүмүүсийг бүгдийг нь нийлүүлээд “бөө” гэдэг нэрэн дор заримдаа хүчээр багтаан, багтахгүйг нь хасах мэтчилэнгээр авч үзсээр ирсэн. Тиймээс бөө гэдэг нэр томъёо өөрөө эрт цагаас хамгийн тодорхойгоор бол XIII зууны үеэс байсан хий хийсгэлэн юмстай харьцдаг гэх хоорондоо холбоотой холбоогүй, төстэй төсгүй янз бүрийн хувь бодгалийг нэрлэдэг байгаад

аажимдаа тэднийг нэгтгэн нэрлэх болсон үүсмэл зохиомол ухагдахуун юм. “Монголын нууц товчооноос” нааш өөр бусад сурвалжуудад мэр сэр бөө гэдэг үг таарахаас гадна монгол үгийн тайлбар толинуудад гарч байна. Тухайлбал, 1717 онд зохиогдсон “Хорин нэгтийн тайлбар толинд” бөө гэдэг үгийг “Хувилгаан онгодод залбиран гуйх хүнийг бөө хэмээмой” ([1717] 1977:274) гэхчилэн тусгай мэргэшил бүхий хүнийг хэлдэг гэж тайлбарласан байна. Түүнээс нэлээд хожим 1926-1929 оны үед зохиогдож байсан Шагжийн толинд “онгодыг биедээ оршуулж гуйн залбирах хүнийг” (Шагж 1994: 297) хэлнэ гэжээ. Энэ мэтчилэн “бөө” гэдэг нэр томъёо ойролцоо утга сэлгэн үе үеийн туршид байсаар ирсэн боловч “бөө мөргөл” гэж дээрх толинуудад ч бусад сурвалж, судалгааны бүтээлийн аль алинд нь тохиолдохгүй байна. Түүнчлэн Б.Ренчингийн (1959, 1961, 1975) эмхэтгэсэн бүтээлийн удиртгал тайлбар сэлтэд *шаманизм* гэж бичсэн байхаас биш яг бөөгийн сан тахилгын судруудын уг эхэд “бөө мөргөл” гэсэн холбоо үг тохиолдохгүй байна. Иймээс “бөө” гэдэг үгийг эрдэмтэн судлаачид “бөө мөргөл” болгосон нь он цагийн хувьд XX зууны дунд үе бололтой. Харин агуулгын хувьд бөө гэдэг нэр томъёо улам өргөжин хүрээ цараагаа тэлж нэгэн хувь бодгалийг заадаг байснаа “-изм”-ийн агуулгатай болон “бөө мөргөл” болжээ. Энэ бол нэг талаар өрнө дахинд хэрэглэгдэж байсан *шаманизм*, *шаманство* хэмээх нэр томъёоны монгол хувилбар гэж ойлгож болох бололтой. Тухайлбал, Банзарын Дорж 1846 онд “Черная вера, или шаманство у монголов” хэмээх судалгаагаа хэвлүүлснийг “Харын шашин-монголын бөө мөргөл” гэж, Б.Я.Владимирцовын 1916 оны “Шаманство в монголли и туркестане” гэдэг өгүүллийг “Туркестан ба монголын бөөгийн мөргөл” хэмээн түүхч Ч.Далай (1959: V) бүтээлдээ тус тус орчуулсан байна. Энэ бол үнэндээ зөвхөн орчуулсан хэрэг биш тэр ухагдахууныг бүрдүүлэн цогцлуулах монгол хэлнээ бүтээх үйл явцын нэгэн хэсэг гэж болно. Өөрөөр хэлбэл монгол соёлд байгаа “бөө мөргөл”, “бөөгийн шашин” хэмээх бүтээмэл ухагдахуун монголоос өмнө Орос болон Европ дахинд “*шаманизм*”, “*шаманство*” гэдэг нэрэн дор бүтэж бүрэлдэж байгаад монголд нэвтэрсэн байна. Ч.Далайгаас гадна Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын тоймын” тэргүүн дэвтэртээ (1957) “Бөөгийн мөргөлийн яруу найраг” гэдэг хэсэг бичиж оруулсан нь анхны тохиолдлуудын нэг бололтой.

“Бөө мөргөл” хэмээх холбоо үгийг анх ямар утгаар хэн, хэрхэн хэрэглэсэн тухай сурвалжлан үзвэл өрнө дахиныхны бөө нэрийн тухай судалгаа ялангуяа Орос хэл дээр хэвлэгдсэн монгол бөө нэрийн судалгаа монголын бөө судлал дах бөө мөргөл гэдэг ухагдахуун бий болоход нөлөөлсөн байна. Энэ бол олон янзын зан үйл, шүтлэг мөргөлийн зүйлсийг бөө гэж нэрлэж болох хүнээр нь холбон нэгтгэж “бөө мөргөлд” хэмээх нэгдсэн бүхэл ухагдахуун болгох үйл хэргийн эхлэл юм. Хэрхэн гэдгийг тайлбарлаваас, тухайлбал, манай ахмад

түүхчид болох Ч.Далай (1959) хожим нь О.Пүрэв (1998) “бөөгийн мөргөлийн түүх”, “бөөгийн шашны түүхийн үечлэл” гэдэг сэдэв гаргаж ирсэн нь өөрөө бөө нэрийн уламжлалыг нэгэн бүхэл зүйл болгон авч үзэж байгаагийн илрэл гэлтэй. Хэрвээ бидний одоо үзэж байгаа шиг бөө мөргөл гэдэг бол тодорхой барьцгүй олон зүйлийн тархай бутархай нэгж нь голлосон зүйл юм бол түүнийг нэгэн түүхтэй гэж үзэх боломжгүй юм. Тиймээс бөө мөргөлийн түүх гэхээсээ илүү монголын түүх, тэр дундаа төрт ёсны түүхэнд бөө нэр болон бөөгийн зан үйл хэрхэн дурдагдаж, хувь нэмэрээ оролцуулсан тухай түүх юм. Мөн Б.Ренчин “бөөгийн дуудлагуудыг”, Ц.Дамдинсүрэн (1957) “бөөгийн мөргөлийн яруу найраг” гэдэг ойлголт бий болгосон нь “бөө нэр аман яруу найрагтай байдаг” гэсэн ухагдахууныг бий болгосон бөгөөд хожим миний бие “бөөгийн аман яруу найргийн төрөл зүйл” (Бум-Очир 2002) гэсэн сэдвээр доктор хамгаалсан нь мөн л ийм тогтсон ухагдахуунд баригдаж байсны ул мөр юм. Гэтэл өдгөө бөө нэр дуудлага тамлагагүй байх нь элбэг тохиолдох болж дуудлага байсан ч тэрийгээ огт хэрэглэхгүй байдал түгээмэл ажиглагдах болжээ. Энэ бол бөө гэдэг дуудлага, тамлагатай байдаг гэдэг тогтсон ойлголт бий болсон байсан нь бүтмэл санаа болохоос биш заавал байх ёстой үнэн бодит байдал биш гэдгийг харуулж байгаа юм. Ийнхүү эхлээд бөө гэдэг нэр томъёон дор нэгдэж байснаа хожим нь “бөө мөргөл” болон бүр сүүлдээ “бөөгийн шашин” болон бүтэж бүрэлдсэн байна.

Иймээс энэ ухагдахууныг үе үеийн бөө нэр өөрсдөө болон бусад олон нийт, засаг захиргаа, яваандаа судлаач эрдэмтэд нэмэн чимсээр “харын шүтлэг” (Банзаров [1846] 1955), “бөөгийн мөргөл” (Бадамхатан 1962, Mansan 1990, Дулам 1992), “шашин” (Buyanbatu 1985, Пүрэв 1998) болгон бүтээсээр ирсэн түүхтэй. Удган, заарин, улаач, саман гэх мэтийн олон үндэстэн, угсаатнуудад байдаг олон янзын мэдлэг мэргэшилтэй хүмүүсийг нэгтгэн бөө гэдэг үгээр томъёолон ойлгох болсон байна. Ийм нэгтгэсэн ухагдахуун улс төр, нийгэм, соёлын олон шалтгаанаар бий болсон байж болох ч ийнхүү нэгтгэх нь нөгөө талдаа хасах, нэмэх, үзэл сурталжуулах, улс төржүүлэх, институтчилэх зохиомол зүйл болгох олон янзын эрсдэлийг бий болгодогийг анхаарах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, нэгэнт тогтчихсон “бөө” гэдэг нэр томъёон дор багтах багтахгүй олон зүйл байгаа юм. Бидэнд одоо байгаа тогтсон ойлголт, тодорхойлолт гэдэг бол үнэндээ бодит байдал гэхээсээ илүү бидний бөө нэрийн тухай зохион бүтээсэн, ургуулан бодож гаргаж ирсэн (constructed concepts) ухагдахуунууд болж таараад байна. Харин чухам хэдий үеэс “бөө” хэмээх нэр томъёо бусад олон зүйлээ өөртөө багтаан нэгэн бүхэл цогцолбор болж ирсэн бэ гэдгийг цаашид гүнзгийрүүлэн судалмаар байна.

“Бөө мөргөл”, “бөөгийн шашин” гэхчилэнгийн нэгтгэсэн ухагдахуун бий болгох нь нэг талаас эмхэн цомнож байгаа барьцтай тодорхой болгож байгаа

боловч нөгөө талаас хязгаарлан зарим зүйлсийг орхин гээгдүүлж соёлын амьд харьцааг нь таслах учир дутадалтай юм. Тухайлбал, бөө гэдэг хүнийг тойрсон бүхнийг оруулан сэтгэх бөө мөргөлтэй ард түмний дунд тархан уламжилсан ёс зүй, хэм хэмжээ, ертөнцийг үзэх үзэл, хорио цээр гэхчилэнгийн олон зүйлийг бөөгөөс хол гэдэг шалтгаанаар эзэнгүйдүүлэн орхиж байгаа юм. Үүний өөр нэгэн томоохон жишээ бол “бөө мөргөл” болон “тэнгэр шүтлэг” хоёрыг *шаманизм, тэнгэрзм* ялган хэмээн тодорхойлж тус тусд нь судлах гэсэн оролдлого юм. Бөө нэрийн зан үйл шүтлэг тахилга, ертөнцийг үзэх үзлийг тэнгэрээс ангид авч үзэх боломжгүйг өмнө өгүүлсэн тэнгэрийн бөө нэрийн тухай хэсэг гэрчилж байгаа юм. Энэ утгаараа тэнгэрийг судлах ажилд бөө нэр ялангуяа мөнх тэнгэрийн гэх бөө нэрийн амьд уламжлал шууд судлагдахуун нь болж байх учиртай болохоос биш *шаманизм, тэнгэрзм* хэмээн ангид авч үзэх нь зүйд нийцэхгүй байна.

Дүгнэлт: Монгол бөөгийн деконстракшны дараа?

Тус судалгаанд авч үзсэн мэдээ баримтаас үзвэл нэгд бөө гэдэг өөрөө байнгын бүтэж бүрэлдэх үйл явцад байдаг орчил хөдөлгөөн байхад нөгөө талд нийгэм олон нийт, улс төр болон нийгмийн зохион байгуулалт, бөө нэр болон бөө шүтлэгтнүүд мөн түүнчлэн түүнийг судлагсад бөөгийн талаарх элдэв санаа оноо ойлголт ухагдахуунуудыг бүтээж байдаг ажээ. Ингээд нарийн судлаж үзвэл нэг талд байнга бүтэж бүрэлдэж байдаг бөө гэгдэгсэд нөгөө талаас түүний тухайт үзэл ухамсар хоёр үл нийцэх авцалдахгүй байдал бий болсон байна. Бидний бөөгийн тухай тогтсон ойлголтууд (dogma) өнөөгийн олон талын шинж чанарыг цогцлуулсан, арвин баялаг, зарим талаар давтагдашгүй нэгж онцлог бүхий шинжийг агуулсан шинэ бөө нэрийн эринд тохирохгүй болж ирчихээд байгаа нь илэрхий юм. Бүр тодруулвал бидэнд байсан “бөө”, “бөө мөргөл”, “бөөгийн шашин” ийм тийм байдаг гэсэн хашин хязгаарлаж тодорхойлсон олон ойлголтууд өнөөдрийн жишээ баримтаар нэгэнтээ таарахгүй охордож байгаа болох нь илэрхий болоод байна. Энэ бол судалгааны түвшинд урьд өмнө хашаалан хумисан тодорхойлолт бүтээн түүнийхээ хүрээнд ойлгодог байсан (construct) зүйлсээ буцаан задлаж (deconstruct) өөр шинэ тодорхойлолт, тайлбар эрж хайх шаардлага тулгарсныг харуулж байгаа юм. Тиймээс нэн тэргүүнээ судлаачдын бий болгосон ойлголтууд буюу *констрактуудыг* саармагжуулан задлаж *деконстракшн* хийх шаардлагатай болсон нь тодорхой байна. Харин бидний дүгнэлтэндээ чухалчилж байгаа гол санаа бол *деконстракшн* хийгээд зогсох биш харин байгаа ойлголтуудыг *деконстракшн хийсний дараа хэрхэх тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл, тогтсон ойлголтуудыг эвдээд ямар нэгэн байдлаар дахин шинэ илүү зүйд* нийцсэн тайлбар (interpretation) боловсруулах тухай асуудал юм. Бидний

санахад бөө болоод түүнтэй шууд болон шууд бус холбоотой элдэв зүйлийг судлана гэдэг бол бөө гэгдэх хүмүүс тэдний үйл хэргийг хашаалан тодорхойлох явдал биш харин соёлын амьд орчин харьцаанд нь зүй тогтолыг нь алдуулалгүйгээр тайлан тайлбарлах явдал юм.

Abstract: We are talking about multiple individuals who are called shamans (*boo*) with radical differences of rank, morality, power, rituals, costumes and deities etc. The variation of rank and other differences can be understood both in terms of individual shaman/spirits moving from one rank to another, and also in terms of particular shamans/spirits with various ranks who are dissimilar to one another because of this ranking. Such a rich variation of shamans and shamanisms help us to critically think about “what we mean by the term shaman (*boo*) and shamanism (*boo morgol*)”. I argue that the ‘shaman’ and ‘shamanism’ can not be treated as concrete entities or stable complexes with defined nature and characteristics. Therefore it is not possible to have an overall definition and structured description of Mongolian shamanism today. Instead shamanism is a variable and heterogeneous ritual and explanatory repertoire which is under the process of construction. The agents who construct this ‘shamanism’ are not just shamans, but include public and scholars who frame and define shamanism as an entity.

Ном зүй

- Бадамхатан, С. 1962. Хөвсгөлийн Цаатан ардын аж байдлын тойм. *Studia Ethnographica*. Том 2. Fasc 1. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл
- Банзаров, Д. 1955. Черная вера или шаманство у монголов, *Собрание Сочинение*. Москва.с. 48-100.
- Бум-Очир, Д. 2002. *Монгол бөөгийн зан үйл: Аман яруу найргийн төрөл зүйлс*. Улаанбаатар: Монгол Улсын Их Сургууль
- Гантогтох, Г. 1999. Бөөгийн шахангийн үг хэллэг. МУИС-ийн МСС-ийн Эрдэм шинжилгээний бичиг, ХҮ боть, хх. 165-169.
- Далай, Ч. 1959. Монгол бөөгийн мөргөлийн товч түүх. *Studia Ethnographica*. Том 1. Fasc 5. Улаанбаатар: Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний хэвлэл
- Дамдинсүрэн, Ц. 1957. *Монголын уран зохиолын тойм*. Нэгдүгээр дэвтэр. Улаанбаатар
- Дулам, С. 1992. *Дархад бөөгийн уламжлал*. Улаанбаатар: Монгол Улсын Их Сургууль
- Пүрэв, О. 1998. *Монгол бөөгийн шашин*. Улаанбаатар: Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи

- Buyanbatu, Kh. 1985. *Monggol boge-iyn shashin-u uchir*. Obur monggol-un soyol-un keblel-un khoriy-a.
- Dumont, L. 1980. *Homo Hierarchicus: The Caste System and Its Implication*. Chicago: Chicago
- Geertz, Clifford. 1973. [2000] *The Interpretation of Cultures*. Basic Books. University Press.
- Humphrey, C. & Thomas, N. 1994. Introduction. In *Shamanism, History and the State*, edited by Nicholas Thomas and Caroline Humphrey, University of Michigan Press.
- Khorin nigetu-yin tayilaburi toil*. 1979. Obur monggol-un soyol-un keblel-un khoriy-a.
- Mansan, D. 1990. *Monggol boge morgul*. Obur monggol-un soyol-un keblel-un khoriy-a.
- Pederson, A. M. 2011. *Not Quite Shamans: Spirit Worlds and Political Lives in the Northern Mongolia*. Ithaca and London: Cornell University Press
- Rintchen, B. 1959. *Les materioux pour l'etude chamanisme Mongol*. 1-Sources litteraires, Otto Harrosswits-Wiesbaden
- Rintchen, B. 1961. *Les materioux pour l'etude chamanisme Mongol*. 2-Textes chamanistes Mongols, Otto Harrosswits-Wiesbaden
- Rintchen, B. 1975. *Les materioux pour l'etude chamanisme Mongol*. 2-Textes chamanistes Mongols, Otto Harrosswits-Wiesbaden
- Shimamura, I. 2004. Reconstructing Identity through Shamanism. *Inner Asia*, Vol 6. No2. pp. 197-215
- Shagj. [1937] 1994. *Monggol uge-yin tayilaburi toil: Ereku-yi-e kilbar bolgon zokiyagsan monggol uge-yin tayilaburi chindamuni-yin erike*. Beijing: Dumdadu ulus-un keblel-un khoriy-a
- Taylor, C. 1992. The Politics of Recognition. In *Multiculturalism and "The Politics of Recognition"* (ed.) A. Gutmann. Princeton & New Jersey: Princeton University Press.
- Walter, Mariko Namba. 2004. Introduction. *Shamanism: An Encyclopedia of world beliefs, practices, and culture*. Eds. Mariko Namba Walter and Eva Jane Neumann Fridman. California: ABC-CLIO. (pp. xv-xxviii)